

Бусдыг удирдан чиглүүл хэмээн дуудсан хүмүүсийг дэмжих талаарх сургаал

1-р хэсэг

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Хэнри Б.Айринг ийн заасан.



Их Эзэний Сүмийн удирдагч тань та нарт сул дорой эсвэл хүчтэй, сүнсээр өдөөгдсөн мэт санагдаж болно. Үнэндээ удирдагч болгонд эдгээр болон өөр олон зан чанар холилдон байдаг. Биднийг удирдахаар дуудагдсан Их Эзэний үйлчлэгчдийг Их Эзэн тэднийг дуудах үед хэрхэн харснаар нь харах юм бол бидний хувьд тэдэнд тусалж байгаа хэрэг юм.

Их Эзэн үйлчлэгчдээ төгс байдлаар хардаг. Тэрээр тэдний чадавх бас ирээдүйг хардаг бөгөөд мөн чанар нь хэрхэн өөрчлөгдөх боломжтойг мэддэг. Удирдах хүмүүсээсээ олж авсан туршлага нь тэднийг хэрхэн өөрчлөх боломжтойг Тэрээр бас мэддэг билээ. . . .

. . . Хэрэв та Их Эзэн дуудсан төгс бус үйлчлэгчдээ өгсөн илчлэлээрээ дамжуулан Сүмээ удирддаг гэдэгт итгэдэг бол Тэрээр тэнгэрийн цонхыг тэдэнд болон өөрт тань мөн адил нээж өгнө. (Хэнри Б. Айринг, "Их Эзэн Өөрийн Сүмийг удирддаг," 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 76-79)

2-р хэсэг

Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч асан Стифэн В.Өвэн ах ийн хэлсэн.



Та нарын амьдралд бусдыг танаар удирдуулахаар дуудах цаг ирнэ. Бусад үед бусдыг дагахыг та нараас хүснэ. Гэвч өнөөдөр миний та нарт өгөх захиас бол та нар ямар дуудлагатайгаасаа үл шалтгаалан үргэлж удирдагч мөн үргэлж дагалдагч байдаг гэсэн захиас юм. Удирдлага нь дагалдагчийн илэрхийлэл юм. Энгийнээр хэлэхэд, энэ нь Христэд ирэхэд нь бусдад туслах явдал бөгөөд жинхэнэ дагалдагчид үүнийг хийдэг. Хэрэв та Христийн дагалдагч болохоор хичээж байгаа бол Түүнийг дагахад бусдад тусалж чадна. Ингэснээр та удирдагч болж чадна.

Таны удирдах чадвар нээлттэй байдал, бусдад урам дэм өгөх чадвар эсвэл олны өмнө ярих авьяасаас ирдэггүй. Энэ нь таны Есүс Христийг дагах амлалтаас ирдэг. (Стифэн В.Өвэн, "Агуу удирдагч агуу дагалдагч байдаг," 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 57-59)

3-р хэсэг

Дараах шүлгүүдийг унш.

Сургаал ба Гэрээ 107:22 (Энэ шүлэг нь Тэргүүн зөвлөлийг дэмжих талаар бидэнд юу зааж байгааг анзаар. Удирдагчдыг дэмжих эдгээр арга зам нь хэрхэн бусад дуудлагад хамаатай байж болох талаар бодож үзээрэй.)

Гэтлэл 17:9-12 (Израил Амалекийн ард түмэнтэй тулалдаж байхад Мосед хэрхэн дэмжин тусалж байсныг анзаарна уу.)